



СЭЛЭНГЭ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/08

Баруун хараа

Хурдан морь унаач хүүхдийн амь нас,  
эрүүл мэндийг хамгаалах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2. Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс сумын хэмжээнд жил бүрийн 11 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01-ийг хуртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосугай.

2. Холбогдох хууль, тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчилж ажиллахыг Багийн засаг дарга, Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ө.Сувд-Эрдэнэ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга /Б.Эрдэнэбаатар/, Цагдаагийн хэсгийн дарга /Л.Гантигчулуун/ нарт үүрэг болгосугай



Р.БАТЖАРГАЛ